

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 02 дугаар сарын 17

Улаанбаатар хот

ДҮД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай 01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагуудаас санал авч, нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж ажиллах.				
1.	Нийслэлийн Засаг даргын “2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай 2022 оны 01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, албадаас нэгдсэн төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн авч, 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 3/277 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны Удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ХОЁР: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хариуцсан ажлын чиглэлээр нийслэлийн иргэдэд боловсрол мэдлэг олгох, соёлыг төлөвшүүлэх, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах, эрүүл мэндийг анхаарах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрэхүйц ажлыг санаачлан зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллах.				
2.	<p>- Дүүргийн харьяа их дээд сургууль, МСҮТ, Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг танхимын хэлбэрээр явуулах болсонтой холбогдуулан Коронавируст (Ковид-19)-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналт шалгалтын ажлыг нийт 84 байгууллагад 2022 оны 2 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд зохион байгуулан зөвлөн тусалж ажилласан.</p> <p>- Ажил идэвхтэй хайж хандсан иргэдийг бүртгэн авч ажил олгогч байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг хүсэл сонирхол, дадлага туршлага, ур чадварыг нь харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн тохирч тэнцэх ажлын байранд холбон зуучлах үйл ажиллагаа явуулж, сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 105, ажил идэвхтэй хайж буй 820 иргэнийг бүртгэж, нийт 48 иргэнийг ажлын байранд зуучлан, 18 шинэ ажлын байрыг бүртгэсэн байна.</p> <p>- Ковид 19 халдварын Омикрон хувилбарын нөхцөл байдалтай холбогдуулан дүүргийн 13 дугаар хороонд байрлах Хайлааст амбулаторийг түшиглэн 50 ор бүхий хэвтүүлэн эмчлэх эмнэлгийг нээн ажиллуулж байгаагаас гадна ковидын халдвар аван эмчлэгдэж буй иргэдэд зориулан Ковидын амбулаторийг давхар нээн ажиллуулж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70